



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2019 оны 12 сарын 23 өдөр

Дугаар А/598


Улаанбаатар хот

Эрүүл мэндийн салбарын шинжлэх
ухааны тэргүүлэх чиглэл батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1. дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн салбарын шинжлэх ухааны тэргүүлэх чиглэл (2020-2025)-ийг хавсралтаар баталсугай.
2. Эрүүл мэндийн салбарын шинжлэх ухааны тэргүүлэх чиглэл (2020-2025)-ийг баримтлан судалгаа, эрдэм шинжилгээний ажлыг зохион байгуулж ажиллахыг анагаах ухааны чиглэлийн их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагуудын дарга, захирал нарт үүрэг болгосугай.
3. Эрүүл мэндийн салбарын шинжлэх ухааны захиалгат ажил болон төсөлт ажлуудыг шинжлэх ухааны тэргүүлэх чиглэлд нийцүүлэн тусган хэрэгжүүлэхийг Төрийн нарийн бичгийн дарга (Я.Амаржаргал)-д үүрэг болгосугай.

САЙД



Д.САРАНГЭРЭЛ

2019-A-tushaal

085021

Эрүүл мэндийн сайдын 2019 оны 12
дугаар сарын 28 -ны өдрийн 1598
дүгээр тушаалын хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ШИНЖЛЭХ УХААНЫ
ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ
(2020-2025 он)

1. НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНД

- Хүрээлэн буй орчны эрүүл мэнд, уур амьсгалын өөрчлөлт;
- Хүнс, хоолны аюулгүй байдал, хүнсний орчин;
- Хүний ба зоонозын халдварт өвчний сэргийлэлт, хяналт, тандалт;
- Халдварт бус өвчин болон осол гэмтлийн эрсдлээс сэргийлэх, тандалт, хяналт;
- Эрүүл мэндийн салбарын бодлого, менежмент, хүний хөгжил;
- Эх хүүхэд, өсвөр үеийн эрүүл мэндийг дэмжих, урьдчилан сэргийлэлт, хяналт, тандалт;

2. БИОАНАГААХ

- Геномикс;
- Үүдэл эсийн судалгаа;
- Биотехнологи;
- Метаболомикс;
- Дархлаа судлал;
- Хавдрын молекул биологийн судлагаа;

3. ЭМ ЗҮЙН УХААН

- Уламжлалт анагаах ухаанд өргөн хэрэглэдэг ургамал, амьтан, эрдсийн гаралтай эмт бодис, уламжлалт жор найрлагын судалгаа;
- Монгол орны эмийн ургамлын фитохими, фармакологийн судалгаа;
- Ховордсон ургамлыг тарималжуулах, нутагшуулах, нөөцийг арвижуулах, генофондыг хамгаалах судалгаа;
- Шинэ эм бэлдмэл зохион бүтээх, эм үйлдвэрлэлд шинэ техник, технологи нэвтрүүлэхэд чиглэсэн судалгаа;
- Эм зүйн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, эмийн зохистой хэрэглээг сайжруулахад чиглэсэн судалгаа;
- Эм зүйн боловсрол, хүний нөөцийн судалгаа;

4. УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААН

- Уламжлалт анагаах ухааны сурвалж бичигт үндэслэн тулгуур нэр томъёог судлан тогтоох, оноох, тодорхойлох, жигдлэх ажлыг хийж, тайлбар толь бүтээх;
- Бодгальд чиглэсэн эмчилгээний аргыг судлах;
- Уламжлалт анагаах ухааны эм найрлагын болон заслын аргын эмнэл зүйн судалгааг хийж үйлдлийн механизмыг судлах;
- Монголчуудын эрүүл амьдрах ухаан болон уламжлалт анагаах ухааны эрүүл амьдрах мэдлэг, дадал, ёс заншлын шинжлэх ухааны үндсийг судлах;
- Уламжлалт болон орчин цагийн цагийн анагаах ухааны аргыг холслуулан хэрэглэх шинжлэх ухааны үндсийг судлан нотолгоожуулах;
- Үр дүн нь уламжлалт анагаах ухааны практикт шууд нэвтрэх боломжтой эм, эмнэл зүйн чиглэлийн судалгааг өргөжүүлэх;

5. ЭМНЭЛЗҮЙН АНАГААХ

- Зүрх, тархины судасны тогтолцооны эмгэг;
- Хорт хавдар;
- Гэмтэл, хордлого, гадны шалтгаант бусад тодорхой эмгэг;
- Хоол боловсруулах тогтолцооны эмгэг;
- Амьсгалын тогтолцооны эмгэг;
- Бөөр шээс дамжуулах тогтолцооны эмгэг;
- Бодисын солилцооны эмгэг (Чихрийн шижин);